# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/

2023-11-17

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ : | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | | |
| 1 | 1 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах | -Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний хөтөлбөр болон нийгмийн баталгаар хангах хөтөлбөрийг байгууллагын даргын 2022 оны А/02 тушаалаар 4 жилийн хугацаатай баталсан.<br>Дээрх хөтөлбөрийн дагуу жил бүр албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, нийгмийн баталгаар хангах төлөвлөгөөг байгууллагын даргын тушаалаар батлан ажилладаг. Дотоод сургалтын төлөвлөгөөг 4 үндсэн сэдвийн хүрээнд 52 сургалтын сэдэвтэй, нийгмийн баталгаар 16 арга хэмжээтэйгээр байгууллагын даргаар батлуулан ажиллаж байна.<br>-Байгууллагын албан хаагчид батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 4 удаагийн сургалтаар албан хаагчид 52 сэдвийн хүрээнд сургалтаа чанартай хийж гүйцэтгэсэн.<br>**Үүний үр дүнд** албан хаагчдын хуулийн болон танин мэдэхүйн мэдлэг нэмэгдэх, хувь хүний хариуцлага, ажилдаа хандах хандлага, зохион байгуулалт сайжрах, нийгмийн баталгаа дээшлэх нэгэн гол хүчин зүйл болж байна. | 100 | | |
| 2 | 2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах. | Байгууллагын эрхэм зорилгыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.<br>Мөн байгууллагын хэмжээнд хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахимаар дараах арга хэлбэрүүдээр байршуулж байна.<br>-Байгууллагын govisumber.gazar.gov.mn сайт нь 11 үндсэн цэс болон 90 дэд цэсэнд нийт 1759 мэдээ мэдээллүүдийг тухай бүр нь байршуулан иргэд, олон нийтэд мэдээлэлсэн. 2023 оны байдлаар | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын сайтанд нийт **253** зар, мэдээ, мэдээлэл, тайлан байршуулсан байна.Үүнд<br>- Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан тушаал шийдвэр **17**,<br>- Сар бүр хийсэн ажлуудын тайлан **10** удаа<br>- Газрын харилцааны чиглэлээрх мэдээлэл **99**<br>- Барилга, хот байгуулалттай холбогдолтой **38**<br>- Өргөдөл, гомдол шийдвэрлэлт **3**<br>- Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүүтэй холбоотой **86** мэдээ, мэдээллийг тус тус байршуулсан байна.<br>Үүнээс гадна байгууллагын пэйж хуудсаар мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулан ажиллаж байна.<br>Мөн мэдээллийг тогтмол график үзүүлэлт, тоон мэдээлэл, зурган мэдээлэл, статистик үзүүлэлтээр гарган оруулж хэвшсэн.<br>Мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулахдаа иргэд томруулж харах, хэвлэж авах болон татаж авах боломжтойгоор байршуулж хэвшсэн.<br>**Үүний үр дүнд** иргэд төрийн үйлчилгээг авахад илүү хялбар, шат дамжлага бага, явдал чирэгдэл багатайгаар хүртэх боломжийг бүрдүүлж байгаа юм. | | | |
| | 3 | | 8.2.2. үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг цахим хуудсанд байршуулах. | Байгууллагын батлагдсан бүтэц орон тоо болон бүтэц зохион байгуулалтын схем зураглал, хаяг, байршил, шуудангийн хаяг, холбогдох утасны дугаар зэргийг байгууллагын цахим сайт болох www.govisumber.gazar.gov.mn сайтанд байршуулсан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт крилл, монгол бичиг хосолсон хэлбэрээр бичиж байршуулсан.<br><br>**Үүний үр дүнд** иргэд, олон нийт шаардлагатай албан хаагчидтай утсаар шууд холбогдох болон байгууллагын бүтэц орон тооны талаар мэдээлэл авах боломжтой. | 100 | | |
| | 4 | | 8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл | | Сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь нийт 141ш мэдээллийг бүрэн байршуулан | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах | ажилласан.Үүнд:<br> Сар бүр цэсэнд 40ш<br> Хагас жил бүр цэсэнд 4ш<br> Жил бүр цэсэнд 5ш<br> Тухай бүр цэсэнд 92ш мэдээллийг тус тус байршуулж мэдээлсэн.<br>- Мөн аудитын дүгнэлт,<br>- Дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт<br>- ХШҮ-ээс өгсөн зөвлөмж<br>- Зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн байршуулсан.<br>Үр дүн: Санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй ил тод тогтмол байршсан. | | | |
| | 6 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан цахим хуудаст байршуулах | Байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллаж буй хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн тайлангуудын 2023 оны хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг гарган цахим хуудсанд “Бодлогын баримт бичгийн тайлагналт” гэсэн цэс үүсгэн байршуулан ажиллаж байна. Үүнд:<br>- Бодлогын баримт бичгийн 4 тайлан<br>- Хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийн 1 тайлан<br>- Аймгийн Засаг даргын захирамжийн биелэлт 1<br>- Байгууллагын үйл ажиллагааны тайлан 2<br>**Үүний үр дүнд** авч хэрэгжүүлж буй ажлын явц үр дүн олон нийтэд нээлттэй ил тод танилцуулагдаж байна. | 100 | | |
| | 7 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах | Байгууллагын **govisumber.gazar.gov.mn** цахим хуудасны хууль тогтоомж цэсэнд 2023 оны байдлаар дээд газраас ирүүлсэн 20 журам, тушаал шийдвэр, дүрэм, зааваруудыг иргэдэд харахад ойлгомжтойгоор, pdf өргөтгөлтэйгээр хэвлэх боломжтойгоор оруулсан. Үүнд:<br>- Засгийн газрын тогтоол 4<br>- БХБС-ын тушаал -3<br>- Дээд газрын тушаал, шийдвэр 8<br>- Аргачилсан заавар 2<br>- Барилгын норм дүрэм 3 байршуулсан байна.<br>**Үүний үр дүнд** иргэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түргэн шуурхай хүртэж, үйлчилгээ авах нөхцөл нэмэгдэж байна | | | |
| | 8 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг цахим хуудаст байршуулах. | -Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2023 оны Б/10 тоот тушаалын дагуу байгууллагын даргын 2023 оны А/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоо, цалин санг шинэчлэн баталсан.<br>Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг<br>➢ Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 360 дугаар тогтоол,<br>➢ Газрын даамлын албан тушаалын тодорхойлолтыг 361 дүгээр тогтоолоор<br>➢ Улсын байцаагч нар, Захиргаа хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нарын албан тушаалын тодорхойлолтыг 2023 оны 368 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж тус тус баталсан.<br>Нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын даргын 2021 оны Б/03, 2023 оны Б/34 дүгээр тушаалаар батлан сайтанд байршуулсан.<br>-Мөн 14 албан хаагчийн овог, нэр, албан тушаал, албаны цахим хаяг, утасны дугаар зэргийг байгууллагын цахим хуудасны хүний нөөц хэсэгт болон байгууллагын мэдээллийн самбарт криллээр болон монгол бичгээр бичиж байршуулан ажилласан.<br>**Үүний үр дүнд:** Иргэд олон нийт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асууж тодруулах зүйлээ холбогдох албан хаагчидтай холбогдон арга зүйн зөвлөгөө авах боломжтой юм. | 100 | | |
| | 9 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг хугацаанд нь гарган мэдээллийн самбар болон цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулах | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр өссөн дүнгээр гаргаж Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Өргөдөл гомдлын мэдээг 1,2,3 дугаар улирлын байдлаа байгууллагын цахим сайт болон өргөдөл гомдлын мэдээллийн самбарт тухай бүр нь байршуулж ил тод мэдээллэсэн.<br>**Үүний үр дүнд:** Иргэд олон нийт байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | харах, танилцахаас гадна байгууллагад ч өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийг хянах  эерэг үр дүнтэй байна. | | | |
| | 10 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Аймгийн статистик мэдээллийг цахим хуудсанд байршуулах. | Байгууллагын цахим сайтын нүүр хуудсанд газартай холбоотой статистик мэдээллийг байршуулсан. Тухайлбал:<br>• Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал<br>• Улсын хэмжээнд газар өмчлөлийн байдал<br>• Үнэгүй газар өмчилж авсан иргэдийг хүн амын тоотой харьцуудсан байдал<br>• Газрын зах зээлийн үнийн мэдээ<br>• Газрын дуудлага худалдааны орлого сум бүрээр<br>• Газрын төлбөрийн орлого сум бүрээр<br>• Цахим өргөдөл, гомдлын шийдвэрлэлт<br><br>**Үүний үр дүнд:** иргэд үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг он тус бүртэй харьцуулан харах боломжтой юм. | 100 | | |
| | 11 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон зохион байгуулсан арга хэмжээг тогтмол байршуулах | • Байгууллагын хэмжээнд газрын даргын тушаал шийдвэрээр болон удирдамж төлөвлөгөөгөөр батлан зохион байгуулсан 15 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжилийг ханган хагас бүтэн жилээр тайлагнаж ажилласан. Үүнд:<br>- Барилгын чиглэлээр 3<br>- Газрын харилцааны чиглэлээр 6<br>- Бусад чиглэлээр 6 арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>**Үүний үр дүнд** Газрын харилцаанаас хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг цаг алдалгүй мэдээлэл авах давуу талтай юм. | 100 | | |
| | 12 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Ажлын байрны сул орон тооны судалгааг тухай бүр шинэчилж цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулах | Сул орон тооны захиалгыг 2023 оны 01/14 тоот албан бичгээр Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газарт Ажлын байрны захиалга өгсөн. Төрийн албаны салбар зөвлөлд 2023 оны байдлаар манай байгууллага  01/37, 01/189, 02/230, 01/259, 01/326 тоот албан бичгээр тус тус  5 удаа захиалга | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгч зарлуулсан байна. Мөн байгууллагын /govisumber.gov.mn/ сайтанд мэдээллийг тухай бүр нь шинэчлэн байршуулсан. Мөн байгууллагын фасэбүүк пэйж хуудсаар сул орон тооны мэдээллийг тухай бүр оруулж байна. **Үүний үр дүнд** 2 албан хаагч ерөнхий болон тусгай шалгалтанд тэнцэж байгууллагын сул орон тоо нөхөгдөж албан хаагчдын ажлын бүтэмж сайжирсан. | | | |
| | 13 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах | Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолыг байгууллагын цахим сайтны ил тод дэд цэсний хүний нөөц цэсэнд болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. **Үүний үр дүнд** иргэд, олон нийт шинэчлэгдсэн журам, заавартай цаг алдалгүй танилцах боломж бүрдэж байгаа юм. | 100 | | |
| | 14 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулах | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г байгууллагын даргын 2023 оны А/12 дугаар тушаалаар шинчлэн баталсан. Байгууллагын ёс зүйн дүрмийг байгууллагын вэб сайт болон мэдээллийн самбарт байршуулан ажиллласан. Мөн Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагын 2023 оны төлөвлөгөө болон хагас жилийн тайлан цахим сайтын Ёс зүйн зөвлөл цэсэд байршуулсан. **Үүний үр дүнд** албан хаагчид ёс зүйн зөрчил дутагдлын талаар мэдлэг мэдээлэлтэй болж урьдчилан сэргийлж чадаж байна. | 100 | | |
| | 15 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 4 жилээр төлөвлөн батлуулж цахим хуудсанд байршуулах | “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 4 жилээр төлөвлөн байгууллагын даргын 2022 оны 01 сарын 24-ний өдрийн А/02 дугаар тушаалаар батлуулж цахим хуудсанд байршуулсан. Үүний үр дүнд хөтөлбөртэй нийцүүлэн жил бүр төлөвлөгөө гарган хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, албан хаагчдын сэтгэл ханамж сайн байна. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 16 | | 8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Аймгийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг тогтмол шинэчлэх | Байгууллагын цахим хуудасны хүний нөөц цэсэнд байгаа мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. Үүнд:<br>• Ажлын байрны сул орон тооны мэдээлэл -3<br>• Байгууллагын албан хаагчдын мэдээлэл, утас, албаны и-мэйл хаяг -5<br>• Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам-1<br>• Сургалтын төлөвлөгөө, тайлан зэрэг мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.<br>**Үүний үр дүнд** сул орон тооны талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр авах боломж бүрдэж байна. | 100 | | |
| | 17 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам болон албан хаагчдыг үнэлсэн үнэлгээг иргэдэд ил тод байдлаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах | Албан хаагчдын үйл ажиллагааг байгууллагын даргын тушаалаар үнэлгээний баг байгуулан үнэлж ажилладаг Хагас жилийн байдлаар албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээр 15 албан хаагчдад нийт 9,033.1 мян.төгрөгийн урамшуулал олгон ажилласан.<br>Жилийн эцсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх хугацаа болоогүй болно.<br>**Үүний үр дүнд** албан хаагчдын ажлын бүтээмж сайжирсан. | 100 | | |
| | 18 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг нийтэд мэдээлэх | 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2026 оны төсвийн төслийн саналыг 01/194 дугаар албан бичгээр дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.<br>Үр дүн: Холбогдох бүх зардлыг тусгаж ирэх онд батлуулахаар төсөвлөсөн. | 100 | | |
| | 19 | | 8.4.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх | Байгууллагын 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг 2023 оны оны 04 дүгээр сарын 25-ны дотор шилэн дансны www.shilendans.gov.mn сайтны бүтэн жилийн мэдээлэл цэсэнд байршуулсан. 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг байгууллагын www.govisumder.gazar.gov.mn сайтанд, ил тодын самбарт тус тус байршуулан ажилласан. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үр дүн: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод ойлгомжтойгоор байршиж иргэн, ААНБ бүрэн танилцах боломжтой. | | | |
| | 20 | | 8.4.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх | Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын санхүүгийн тайлангийн өөрчлөлтгүй санал дүгнэлтийг shilendans.gov.mn сайтанд болон байгууллагын www.govisumder.gazar.gov.mn сайтанд тус тус байршуулан ажилласан.<br>Үр дүн: Зөрчилгүй санал дүгнэлт авсан. | 100 | | |
| | 21 | | 8.4.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоосон шийдвэрийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулах. | 2023 оны тухайн тайлант хугацаанд барилга техник хяналтын зардлын орлогоос нийт 75,284,289.60 төгрөг, газрын үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,151,580 төгрөгийн тус тус санхүүжилтийн орлогоор санхүүжсэн.Орлогыг шилэн дансны shilendans.gov.mn сайт болон байгууллагын www.govisumder.gazar.gov.m цахим сайтаанд тус тус мэдээлэн байршуулсан.<br>Үр дүн: Санхүүгийн үйл ажиллагаа ил тод байршсан. | 100 | | |
| | 22 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулах | Байгууллагын 2023 оны жилийн нийт батлагдсан төсөв 545,431,600.0 төгрөг, 2023 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар нийт төсөв 437,929,800.0 төгрөг, төсвийн гүйцэтгэл 10 дугаар сарын 31-ны байдлаар өссөн дүнгээрээ 326,392,642.91 төгрөг, хэмнэгдсэн төсөв 111,537,157.09 төгрөгөөр тайлагнагдсан. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хэмнэлт,хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг www.shilendans.gov.mnсайтны сар бүрийн цэсэнд дараа сарын 8-ны дотор буюу хуулийн хугацаанд нь нийт 10ш мэдээллийг байршуулан ажилласан.<br>Үр дүн: Төсөв хэмнэсэний үр дүнд тайлант хугацаанд өглөг, авлага үүсгээгүй ажилласан. | 100 | | |
| | 23 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг | www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаарх тайлант хугацаанд 5 саяас дээш үний дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээ буюу барилга техник хяналтын зардлаас тоног төхөөрөмж худалдан авсан нийт 16,571,800.0 төгрөгийн мэдээллийг тус | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх | тус тухай бүрд цэсэнд байршуулан ажилласан.<br>Үр дүн: Хуулийн хугацаанд ил тод байршсан. | | | |
| | 24 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх | www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаарх тайлант хугацаанд 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний зардал буюу орлогын мэдээллийг тус тус тухай бүрд цэсэнд байршуулан ажилласан.Үүнд өссөн дүнгээрх орлого:<br>Санхүүжилтийн орлого 490,931,400.0 мян.төг<br>Хяналтын зардлын орлого 75,284,289.60 төгрөг<br>Үндсэн үйл ажиллагааны орлого 1,198,611.0 төгрөг<br>Зарлага:<br>Тоног төхөөрөмжийн зардалд 16,571,800.0 төгрөгийг тус тус мэдээлж байршуулан ажилласан.<br>Үр дүн: Төсвийг үр ашигтай зарцуулан ажилласан. | 100 | | |
| | 25 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Аймгийн төсөв баталсан болон төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоолуудыг нийтэд мэдээлэх | ❖ Байгууллагын төсөвт 2023 оны 06 сард төсвийн тодотголоор өөрчлөлт орж 545,5 сая төгрөг болож нэмэгдсэн тогтоол шийдвэрийг байршуулан ажилласан.<br>Үр дүн: Санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй ил тод байршсан. | 100 | | |
| | 26 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулж, нийтэд мэдээлэх | www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь нийт 141 ш мэдээллийг бүрэн байршуулан ажилласан.Үүнд:<br>✓ Сар бүр цэсэнд 40ш<br>✓ Хагас жил бүр цэсэнд 4ш<br>✓ Жил бүр цэсэнд 5ш<br>Тухай бүр цэсэнд 92ш мэдээллийг тус тус байршуулж мэдээлсэн.<br>Үр дүн: Санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй ил тод тогтмол байршсан. | 100 | | |
| | 27 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, | Төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалтыг зохион | Тухайн тайланд хугацааны худалдан авалтанд тендер шалгаруулалтын үйл ажиллагаа хийгдээгүй | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | байгуулж, үр дүнг тухай бүр ил тод мэдээлэх | болно. | | | |
| | 28 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Төрийн аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цахим хуудсанд байршуулах | 2022 оны жилийн эцсийн аудитын санхүүгийн тайлангийн өөрчлөлтгүй санал дүгнэлтийг шилэн дансны www.shilendans.gov.mn сайтны жилийн мэдээлэл цэсэнд хуулийн хугацаанд,байгууллагын www.govisumder.gazar.gov.mn цахим сайтанд тус тус байршуулан ажилласан.<br>Үр дүн: Зөрчилгүй санал дүгнэлт авсан. | 100 | | |
| | 29 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Хөрөнгө оруулалтын ажлуудын техникийн тодорхойлолт болон зургийн даалгаварыг боловсруулахад хамтран ажиллах | Холбогдох байгууллагуудын саналаар:<br>-Техникийн тодорхойлолт-5<br>-Зургийн даалгавар -3 –г тус тус хамтран боловсруулсан.<br>- Худалдан авалтын ажлын хэсэгт 1 удаа орж ажиллаж зөвлөгөө, зөвлөмж өгч хамтран ажилласан байна.<br>**Үүний үр дүнд** хөрөнгө оруулалтын ажил стандарт норм дүрмийн дагуу чанартай хийгдэж, төсвийн хөрөнгө оруулалт үр ашигтай зарцуулагдах нөхцөл бүрдэх юм. | 100 | | |
| | 30 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, | Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн ажил | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа нийт 25 ажилд барилга захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн | 100 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 31 | | тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | захиалагчийн хяалтыг хэрэгжүүлэх, үе шатны ажлын санхүүжилтийг батлах, ажлын мэдээллийг цахим сайтад байршуулах | ажиллаж байна. Барилга угсралт, засвар тохижилт, шугам сүлжээний ажлуудын ажлын явц, ашиглалтад оруулсан мэдээлэл, салбарын үйл ажиллагааны мэдээлэл зэргийг тухай бүр байгууллагын цахим сайтанд 31 мэдээлэл www.govisumder.gazar.gov.mn цахим сайт,байгууллагын facebook хаяг, gsa.barilga2 цахим группь зэрэгт мэдээллийг тус бүр байршуулан ажиллаж байна. Үүний үр дүнд Хөрөнгө оруулалтын ажил стандарт норм дүрмийн дагуу чанартай хийгдэж, төсвийн хөрөнгө оруулалт үр ашигтай зарцуулагдах нөхцөл бүрдэх юм.<br>**Үүний үр дүнд** хөрөнгө оруулалтын ажил стандарт норм дүрмийн дагуу чанартай хийгдэж, төсвийн хөрөнгө оруулалт үр ашигтай зарцуулагдах нөхцөл бүрдэх юм. | | | | |
| | 31 | | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Барилга байгууламжийг холбогдох дүрэм, журмын дагуу байнгын ашиглалтад оруулах | 2023 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 шугам сүлжээний ажил, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын 3 барилга угсралтын ажил байнгын ашиглалтад орсон байна.Үүнд:<br>1.Баянтал сумын Лүн гэр хорооллын ЦДАШ-н ажил<br>2.Сүмбэр сумын Бурхант шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах ажил<br>3. Иргэн Л.Элбэгийн худалдаа, үйлчилгээний барилга<br>4. Шивээговь сумын Төрийн банкны барилга<br>5. Иргэн С.Гансүхийн худалдаа, үйлчилгээний барилга<br>6.Сүмбэр сумын 4-р баг,Тэрэгтэд 6кв-н ЦДАШ, 250кВа трансформаторын дэд өртөөний ажил<br>**Үүний үр дүнд:** Холбогдох норм дүрэм, стандартын хэрэгжилт хангагдаж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах нөхцөл хангагдана. | 100 | | | |
| | 32 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах. | Байгууллагын www.govisumder.gazar.gov.mn цахим сайтны төсөв санхүү болон статистик цэсэнд нийт 12 ширхэг, шилэн дансны www.shilendans.gov.mn цахим сайтанд нийт 141 ширхэг мэдээллийг хүснэгтэн болон график үзүүлэлтээр, мөн байгууллагын ил тодын самбарт тус тус ил тод | 100 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана: | | байршуулсан.<br>**Үүний үр дүнд** төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг он, оноор график үзүүлэлтээр харах боломж бүрдсэн. | | | |
| | 33 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Аймгийн хэмжээнд гарч буй захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах. | Газрын багц хууль болон Геодези, зураг зүйн тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдрүүдийн хооронд иргэд, олон нийтийн дунд хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан.<br>Мөн Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт буюу Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, үнэлгээний суурь үнэ өөрчлөхтэй холбогдуулан иргэд, олон нийтээс цахимаар санал авч ажилласан.<br>**Үүний үр дүнд** иргэд олон нийт шинэчлэгдэж буй багц хуулийн төслийн талаар мэдээлэл авч холбогдох хуулийн талаар илүү мэдээлэлтэй болсон давуу талтай. | 100 | | |
| | 34 | | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээллийг egazar.gov.mn систем байршуулах. | Сумдын 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө болон тодотголыг байгууллагын Govisumber.gazar.gov.mn сайт болон www.egazar.gov.mn сайтанд иргэд, олон нийт татаж авахаар байршуулсан.<br>Үүнд:<br>- Сүмбэр сумын 2022 оны 05, 2023 оны 04 дүгээр тогтоол<br>- Баянтал сумын 2022 оны 07 дугаар тогтоол<br>- Шивээговь сумын 2022 оны 08 дугаар тогтоолуудыг байршуулснаас гадна дуудлага худалдааны явцын мэдээллүүд болон төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг цахимаар хянуулан зөвлөгөө чиглэл авч ажиллаж байна.<br>Төлөвлөгөө ил тод олон нийт танилцах, оролцох боломж бүрдсэн.<br>**Үүний үр дүнд** иргэд олон нийт тухайн жилийн газар олголтын талаарх мэдээллийг цаг алдалгүй авах боломж бүрдсэн. | 100 | | |
| | 35 | | 8.6.4. мэдээлэл | Төсвийн болон орон нутгийн | 35 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | өмчийн байгууллагуудын эзэмшиж байгаа газрын мэдээллийг | этгээдийн 115 нэгж талбарын мэдээлэл буюу газрын хэмжээ, зориулалт, байршил зэрэг холбогдох мэдээллийг байгууллагын Govisumber.gazar.gov.mn цахим хуудсанд байршуулан ажилласан.<br>**Үүний үр дүнд** мэдээлэл ил тод иргэд олон нийт танилцах нөхцөл боломж бүрдсэн. | | | |
| | 36 | | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогыг иргэдэд мэдээлэх | 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил газрыг иргэн, хуулийн этгээдэд шилжүүлж, ашиглуулсан шийдвэр гараагүй болно.<br>**Үүний үр дүнд** холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 | | |
| | 37 | | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлтийг ил тод мэдээлэх | 2023 оны жилийн эцсийн байдлаар 6 барилга угсралтын ажилд улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулах дүгнэлт гарсан байна. Үүнд<br>1 Баянтал сумын Лүн гэр хорооллын цахилгаан хангамжын ажил<br>2. Сүмбэр сумын Бурхант гэр хорооллын цахилгаан хангамжын ажил<br>3. Сүмбэр сумын иргэн Л.Элбэгийн худалдаа үйлчилгээний газар<br>4.Шивээговь сумын төрийн банкны барилгын ажил<br>5. Сүмбэр сумын иргэн С.Гансүхийн худалдаа үйлчилгээний газар<br>6. Сүмбэр сумын Тэрэгт суурьшлын бүсийн цахилгаан хангамжын ажил<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын 2013.04.17-ны өдрийн 01 дүгээр “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх турай албан даалгаварын 1.2-д “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гаргасан дүгнэлтийг нэгтгэн ирүүлэх” гэж тусгагдсаны дагуу эхний ээлжинд 2020-2023 онд байнгын ашиглалтад оруулсан барилга угсралтын 6 ажлын комиссын | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгнэлт, саналын хуудасыг хавсралт маягтын дагуу гарган 2023.05.17-ны өдөр ГЗБГЗЗГ-ын Хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн Э.Бүжинлхамд bujinlkham.e@gazar.gov,mn хаягаар хүргүүлсэн.<br><br>**Үүний үр дүнд** нээлттэй ил тод, мэдээ мэдээллээр хангах нөхцөл бүрдэнэ. | | | |
| | 38 | | 8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Шивээ овоо ХК-тай байгуулсан гэрээг цахим хуудсанд байршуулах. | Шивээ-овоо ХК-ийн 901 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг кадастрын мэдээллийн санд бүртгэн оруулж, газар эзэмших гэрээг байгуулан 109.1 сая төгрөгийн төлбөрийг шинэчлэн батлагдсан тогтоолын дагуу ногдуулж, нэхэмжлэх үүсгэж татварын системд илгээсэн.<br><br>**Үүний үр дүнд** аймаг, орон нутгийн төсөвт төвлөрөх газрын төлбөрийн хувь хэмжээ ихэссэн. | 100 | | |
| | 39 | | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | И-Монголиа, egazar.gov.mn хуудасны аймгийн цахим хуудастай холбох | Газрын харилцааны www.egazar.gov.mn цахим сайт болон www.e-mongolia.mn сайтуудын аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим сайт болон байгууллагын цахим сайттай холбон ажилласан.<br><br>**Үүний үр дүнд** иргэд олон нийт төрийн үйлчилгээг шууд авах боломж бүрдсэн. | 100 | | |
| **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | | | |
| 3 | 40 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр | - Бүх шатны байгууллагын гадна, дотно хаягийг хос бичгээр бичих ажлыг зохион байгуулах<br><br>- Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжих | -Байгууллагын гадна хаяг болон хэлтсүүдийн өрөөний хаяг нийт 3 ширхэг хаягийг 83’300 төгрөгийн зардлаар стандартын дагуу хос бичгээр бичүүлэн байршуулсан. Мөн өрөөнүүдийн доторх хаяг болон байгууллагын тугийг хос бичгээр гаргуулсан.<br><br>-Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2018_46 | бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | | байгууллагын албан хаагчид угийн бичгийн шаштирыг монгол бичгээр хөтлөн ажиллаж байна.<br><br>-Байгууллагын цахим сайтны монгол бичиг цэсэнд 7 мэдээлэл, 3 төрлийн гарын авлагыг байршуулсан.<br><br>-Байгууллагаас илгээж буй албан бичгүүдийг монгол бичгээр гарган ажиллаж байна. 2023 онд 24 бичгийг илгээсэн байна.<br><br>-Нийт 600 ширхэг албан бланкийг 90,000 төгрөгөөр захиалсан. Үүнд: 200 ширхэг тушаалын бланк, 400 албан бичгийн А4,А5 хэмжээтэй бланк захиалсан.<br>**Үүний үр дүнд** албан хаагчид болон иргэд олон нийтийн монгол бичгийн унших чадвар сайжрах боломж бүрдсэн. | | | |
| | 41 | | 4. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Монгол бичгийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн зохион байгуулах | Монгол бичгийг сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс байгууллагын хэмжээнд төлөвлөгөө боловсруулан ажилласан бөгөөд холбогдох дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:<br>- Хүмүүн бичиг сонинг бүтэн жилээр 2 жилийн турш захиалж албан хаагчдаар судлуулж байна<br>- Монгол бичгийн самбар байгуулж 7 төрлийн мэдээ мэдээллийг монгол бичгээр гарган байршуулж байна<br>- Албан хаагчдын түвшинг тогтоосон<br>- Эрхэмлэх 9 зүйл болон Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг Монгол бичгээр бичиж байгууллагад байршуулсан<br>- Албан хаагчдын мэдээллийг монгол бичгээр гарган байрлуулсан<br>- Дотор гадна хаягуудыг монгол бичгээр бичиж байршуулсан<br>- Байгууллагаас илгээж буй албан бичгүүдийг хос бичгээр гарган ажиллаж байна.<br>- Албан хаагчдын компьютерт монгол бичгийн фонд суулгах зэрэг ажлуудыг санаачлан зохион байгуулж байна. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Монгол бичгээр албан тоот явуулж байна.<br>**Үүний үр дүнд** албан хаагчдын мэдлэг дээшилж, хэрэглэх сонирхолтой болж байна. | | | |
| 4 | 42 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах | Орон нутгийн төсвийн нэг хувиас доошгүй хөрөнгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд зарцуулах | Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд манай байгууллага 2023 онд нийт 144 ширхэг мод 450,000 төгрөгийн зардлаар тарьж, арчилж байна.<br>Аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүргийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр нийт 240,000 төгрөгийн өртөг бүхий 60 ширхэг модыг Ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьсан.<br>2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нийт 135,000 төгрөгийн өртөг бүхий 54 ширхэг модыг байгууллагынхаа хуваарьт талбайд, 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр нийт 75,000 төгрөгийн өртөг бүхий 30 ширхэг модыг Ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьсан байна. Үүнд:<br>❖ 90 ширхэг хайлаас Ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьсан.<br>❖ 54 ширхэг хайлаас Байгууллагынхаа хуваарьт талбайд тарьсан.<br>Мөн түүнчлэн байгууллагын хариуцсан талбайн хог хаягдлыг цэвэрлэж, тогоог сэргээх, усалгааг хийх, нөхөн сэргээх, хашаа хайсыг янзлах, хамгаалах арга хэмжээг авч ажилласан. 2023 онд усалгааг нийт 9 удаа хийсэн байна.<br>**Үүний үр дүнд** аймаг, орон нутгийн өнгө үзэмж сайжирч ногоон байгууламж нэмэгдэх нөхцөл бүрдсэн. | 100 | | |
| | 43 | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, | Орон нутгийн хөрс, цөлжилтийн судалгааны дүгнэлтийн дагуу ургамлыг нутагшуулах судалгааны ажлыг хийх.<br>Цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулан, техник технологийг шинэчлэх аймаг, сумдын нэгдсэн төлөвлөлттэй | Аймгийн хэмжээнд 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд газар хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр 10945.3509 га газрыг төлөвлөн сумдын ИТХ-аар батлуулан ажилласан. Үүнд:<br>• Сүмбэр сум 129.7872 га<br>• Баянтал сум 5010 га<br>• Шивээговь сум 3305.5637 га<br>**Үүний үр дүнд** ургамлын ургах чадавхи сайжрах | 100 | | |

| | | | Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав; | | явган зам 360м, дугуйн зам 360м тус тус хийгдсэн.<br><br>Хүрсэн түвшин: Явган зам-5510м, дугуйн зам 7110м ажил хийгдсэн. | | | |
| | 70 | | XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд | Тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах, сурталчлах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулж, үр | -Албаны тоон гарын үсгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт уламжлан байгууллагын 12 албан хаагч Үндэсний дата төвөөс 2021 онд бүрэн авсан. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | дүнг нэгтгэн тайлагнах | -Иргэний тоон гарын үсгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2022-2023 онд 13 албан хаагч авсан.<br>**Үүний үр дүнд:** Тоон гарын үсгийг ашиглан цаг хугацаа хэмнэн үйл ажиллагаандаа ашиглаж байна**.** | | | |
| 25 | 71 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн | Албан бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллах | ERP mongolia цахим системийг 2022 оноос хойш ашиглаж эхэлсэн. 2023 оны байдлаар ERP цахим системээр ирсэн бичиг 135, явсан бичиг 111 байна. Мөн ERP mongolia цахим системийн хүний нөөцийн удирдлага цэсний албан тушаал хэсэгт нийт 15 албан тушаалын мэдээлэл болон А, Б анкетыг оруулсан. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | | Манай байгууллага нь БХБЯ-аас салбарын хэмжээнд нэгдсэн системээр албан хэрэг хөтлөлтийг 2017 оноос эхлэн ABLE программ ашиглаж хэвшсэн.<br>Үүний дүнд ABLE программ болон газрын цахим системүүдээр дамжуулан цахим архивыг үүсгэсэн. | | | |
| 26 | 72 | 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2022-08-17 Дугаар 2022_41 | ҮIII.6. . “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, | -Засгийн газрын үйл ажиллагааны зорилт, арга хэмжээ хангагдсан байна.<br>-Шинэчлэгдэж буй хуулийн төслийг иргэд, олон нийтэд таниулах хэлэлцүүлэг зохион байгуулах | -2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 13 арга хэмжээний хүрээнд 96.1 хувийн хэрэгжилттэй байна.<br>-Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль шинэчлэгдэж байгаатай холбогдуулан Газрын багц хуулийн хэлэлцүүлэгийг аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдрүүдийн хооронд зохион байгуулан ажилласан. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт тус тус даалгав:<br>1.1. Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх;<br>1.2. Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээг улсын төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх;<br>1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх; | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 73 | | 1.4. Улсын Их Хуралд энэ онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар нэн даруй хэлэлцүүлж, өргөн мэдүүлэх. | | | | | |
| 27 | 73 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | Х.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Төрийн байгууллагатай хамтран ажиллах | Хуулийн хүрээнд төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх ажлын хүрээнд нийт 68 төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг цахим болгон ажилласан.<br><br>**Үүний үр дүнд** төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ цахим хувь болсон. | 100 | | |

| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 74 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах. | Албаны тоон гарын үсгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт уламжлан байгууллагын 12 албан хаагч Үндэсний дата төвөөс 2021 онд бүрэн авсан.<br>-Иргэний тоон гарын үсгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2022-2023 онд 13 албан хаагч авсан.<br>**Үүний үр дүнд:** Тоон гарын үсгийг ашиглан цаг хугацаа хэмнэн үйл ажиллагаандаа ашиглаж байна | 100 | | | |
| | 75 | | 3. Хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй хоблогдуулан хуульд заасан бусад тохиолдолд иргэний хурууны хээг таниулж үйлчилгээ үзүүлж байгааг үе шаттай зогсоох, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, хууль, хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагын дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирал нарт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын | | 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан биеийн давхцахгүй өгөгдөл /хурууны хээ/-ийг ашиглахаа зогсоож сумдын газрын даамлууд болон аймгийн Кадастрын мэргэжилтэнд байсан хурууны хээний 4 ширхэг төхөөрөмжийг хураан авсан. мөн цагийн бүртгэлийн 1 төхөөрөмжийг хурааж ашиглахаа больсон. | 100 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үүрэгн хариуцагч Л.Энх-Амгаланд тус тус үүрэг болгосугай. | | | | | | |
| | 76 | | 4. Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр нийтэлж байхыг Засгийн газрын гишүүд, хууль, хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай. | | -Байгууллагын govisumber.gazar.gov.mn сайт нь 11 үндсэн цэс болон 90 дэд цэсэнд нийт 1759 мэдээ мэдээллүүдийг тухай бүр нь байршуулан иргэд, олон нийтэд мэдээлэлсэн. 2023 оны байдлаар байгууллагын сайтанд нийт **253** зар, мэдээ, мэдээлэл, тайлан байршуулсан байна.Үүнд<br>- Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан тушаал шийдвэр **17**,<br>- Сар бүр хийсэн ажлуудын тайлан **10** удаа<br>- Газрын харилцааны чиглэлээрх мэдээлэл **99**<br>- Барилга, хот байгуулалттай холбогдолтой **38**<br>- Өргөдөл, гомдол шийдвэрлэлт **3**<br>- Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүүтэй холбоотой **86** мэдээ, мэдээллийг тус тус байршуулсан байна.<br>Үүнээс гадна байгууллагын пэйж хуудсаар мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулан ажиллаж байна.<br>Мөн мэдээллийг тогтмол график үзүүлэлт, тоон мэдээлэл, зурган мэдээлэл, статистик үзүүлэлтээр гарган оруулж хэвшсэн.<br>Мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулахдаа иргэд томруулж харах, хэвлэж авах болон татаж авах боломжтойгоор байршуулж хэвшсэн.<br>**Үүний үр дүнд** иргэд төрийн үйлчилгээг авахад илүү хялбар, шат дамжлага бага, явдал чирэгдэл багатайгаар хүртэх боломжийг бүрдүүлж байгаа юм. | 100 | | |
| 29 | 77 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6 | 1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын | | "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого зорилтын хүрээнд 3.6. дахь заалтанд Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс гэж заасны дагуу 7 заалт,<br>Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилтын хүрээнд төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна гэж заасны дагуу 9 заалтын биелэлтийг гаргаж дээд шатны байгууллагад | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | | хүргүүлээд байна.<br>Байгууллагын албан хаагчдыг хамруулсан дотоод сургалтын хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийнбодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга М.Анхбаяраар сургалт хийлгэж мэдээлэл өгсөн. | | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | | |
| 30 | 78 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09 | 1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх | Дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэх | -Дахин төлөвлөлтийн ажлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг “Жаргалант хийц” ХХК-тай 18,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэж, хүлээлгэн өгөх шатандаа байна.<br>-Барилга, хот байгуулалтын яамтай хамтран ажиллаж байгаа Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн үнэлгээг хэрэгжүүлж буй зөвлөх баг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Говьсүмбэр аймагт ажилласан. Уулзалтын санал дүгнэлтээр дахин төлөвлөлт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн гадна инженерийн шугам сүлжээний бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэцийн асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэх, судалгаа шинжилгээний ажлыг нарийвчлан гаргах, дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг асуудлыг тодотгосон.<br>2023 онд дахин төлөвлөлтийн ажлын төлөвлөлтийн зураг төслийг боловсруулж дуусахад цахилгааны техникийн нөхцөл олгох асуудал шийдвэрлэгдэхгүй хугацаа алдсан болович БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр салбараас техникийн нөхцлийг олгохоор | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшилцөлд хүрч, техникийн нөхцөл авах шатандаа байна.<br><br>Байгууллагын зүгээс төслийн судалгааны ажил, зураг төслийн төлөвлөлтийн зургийг хянах ажилд хамтран ажилласан.<br><br>Хүрсэн түвшин: Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөний зургийн явц 90 хувьтай. | | | |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | | | | | | | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | | |
| 31 | 79 | Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-07-20 Дугаар 2021_212 | 2. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Шинэчлэн батлагдсан дүрмийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, аймаг, нийслэлийн хэмжээнд хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоол, “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт | Холбогдох дүрмийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах | Засгийн газрын 2021 оны 212 тогтоол “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 шугам сүлжээний ажил, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын 3 барилга угсралтын ажил байнгын ашиглалтад орсон байна.Үүнд:<br>1.Баянтал сумын Лүн гэр хорооллын ЦДАШ-н ажил<br>2. Сүмбэр сумын Бурхант шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах ажил<br>3. Иргэн Л.Элбэгийн худалдаа, үйлчилгээний барилга<br>4. Шивээговь сумын Төрийн банкны барилга<br>5. Иргэн С.Гансүхийн худалдаа, үйлчилгээний барилга<br>6.Сүмбэр сумын 4-р баг,Тэрэгтэд 6кв-н ЦДАШ, 250кВа трансформаторын дэд өртөөний ажил<br>**Үүний үр дүнд:** Холбогдох норм дүрэм, стандартын хэрэгжилт хангагдаж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах нөхцөл хангагдана. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. | | | | | |
| 32 | 80 | Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2022-05-04 Дугаар 2022_180 | 3.Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хаягжуулах ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хаягжуулалтын үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | -Хаягжуулалтын мэдээллийн системд орж баталгаажсан нэгж талбар, барилгын орц, гарцыг тодорхойлон ажиллах | Аймгийн хэмжээнд 2017-2020 хооронд нийт 87,5 сая төгрөгийн төсвөөр 3652 ширхэг хаягийн тэмдэгийг хийлгэн байршуулсан.<br>2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 12459 нэгж талбараас 11456 нэгж талбар, 2469 барилгаас 2201 барилгын орц, гарцыг тодорхойлон 91,4%-ийн гүйцэтгэлтэй орц, гарцыг тодорхойлон ажилласан байна.<br>**Үүний үр дүнд** айл өрхийн орц, гарцын мэдээлэл мэдээллийн санд орсон давуу талтай. | 100 | | |
| 33 | 81 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5.2 Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн крилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх | Цахим орчинд монгол бичгээр бичиж сурах | Байгууллагын цахим хуудсанд мэдээ, мэдээллийг крилл, монгол бичгээр хослуулан бичих үүднээс албан хаагч бүр гар утсандаа монгол бичгийн “Chimee” аппликейшн суулгаж, “Кимо” сайтын тусламжтай үгийн алдааг шалгаж, “Болор толь” ашиглан өдөр тутмын үйл ажиллагаандаа цахим орчинд бичих дадал хэвшүүлж байна. Монгол бичгийн үсгийн фонтыг албан хаагч бүрийн компьютерт суулган мэдээ, мэдээлэл, гарын авлагыг | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 5.4 Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах | | хос бичгээр бичиж иргэдэд үйлчлэн ажиллаж байна. Үүний үр дүнд байгууллагын цахим сайтны монгол бичиг цэсэнд цаг үеийн 7 мэдээ, мэдээлэл, 3 төрлийн гарын авлага оруулан ажилласан. | | | |
| | 82 | | | Мэдлэг чадварыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах, уралдаан тэмцээнд оролцох | Монгол бичгийг сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс байгууллагын хэмжээнд төлөвлөгөө боловсруулан ажилласан бөгөөд холбогдох дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:<br>- Аймаг орон нутгаас зохион байгуулсан олимпиад тэмцээн уралдаанд байгууллага хамт олннороо 1 удаа оролцсон<br>- Хүмүүн бичиг сонинг бүтэн жилээр 2 жилийн турш захиалж албан хаагчдаар судлуулж байна<br>- Монгол бичгийн самбар байгуулж мэдээ мэдээллийг монгол бичгээр бичүүлж байршуулж байна<br>- Албан хаагчдын түвшинг тогтоосон<br>- Эрхэмлэх 9 зүйл болон Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг Монгол бичгээр бичиж байгууллагад байршуулсан<br>- Албан хаагчдын мэдээллийг монгол бичгээр гарган байрлуулсан<br>- Дотор гадна хаягуудыг монгол бичгээр бичиж байршуулсан<br>- - Албан хэрэг хөтлөлтийг монгол бичгээр эрхэлж эхэлсэн бөгөөд 600 бланк захиалж 24 албан бичгийг монгол бичгээр илгээсэн байна. | 100 | | |
| | 83 | | | 5.5 Төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх | - Гадна хаяг болон хэлтсүүдийн өрөөний хаяг буюу нийт 3 ширхэг хаягийг 83300 төгрөгийн зардлаар стандартын дагуу хос бичгээр бичүүлэн байршуулсан.<br>- Хэлтсүүдийн дотор хаягийг болон байгууллагын тугийг монгол бичгээр бичиж байршуулсан.<br>- Цахим сайтад монгол бичгийн булан нээж, албан хаагчдын нэр, албан тушаал, утасны дугаарыг монгол бичгээр бичүүлж байршуулснаас гадна мэдээллийн самбарт байршуулсан.<br>-600 ширхэг албан бланкийг 90,000 төгрөгөөр захиалсан. Үүнд: 200 ширхэг тушаалын бланк, 400 албан бичгийн А4, А5 хэмжээтэй бланк захиалсан. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 84 | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-12-22 Дугаар 2022_388 | 5.Төсвийн хэмнэлтийн горимд дараахь чиглэлийг баримтлан ажиллаж өр, авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд захирагч нарт тус тус даалгасугай. | Өр, авлага үүсгэхгүй төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах | 2023 оны тухайн тайлант хугацаанд шинээр өглөг, авлага үүсгээгүй, төсвийг зориулалтын дагуу төсвийн хэтрэлтгүй ажиллаж байна. | 100 | | |
| 35 | 85 | "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах<br><br>2021-04-28 Дугаар 2021_109 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хуульд заасан мэдээллийн ил, тод нээлттэй байдал<br><br>Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал<br><br>Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1 –д заасан төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилтийг хангаж ажиллах | - Байгууллагын govisumber.gazar.gov.mn сайт нь 11 үндсэн цэс болон 90 дэд цэсэнд нийт 1759 мэдээ мэдээллүүдийг тухай бүр нь байршуулан иргэд, олон нийтэд мэдээлэлсэн. 2023 оны байдлаар байгууллагын сайтанд нийт **253** зар, мэдээ, мэдээлэл, тайлан байршуулсан байна.<br><br>-www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь нийт 141 ш мэдээллийг бүрэн байршуулан ажилласан<br><br>-Байгууллагын 2023 оны авилгын эсрэг төлөвлөгөөг нийт 16 арга хэмжээтэйгээр төлөвлөн газрын даргаар батлуулсны дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. Хагас жилийн хэрэгжилтийг гарган байгууллагын цахим хуудасны ил тод цэсний Авлига ашиг сонирхол цэсэнд төлөвлөгөөний хамт байршуулсан. | 70 | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 86 | 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2021-03-17 Дугаар 2021_18 | XY.7.2. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын явцын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Төслийг боловсруулах, батлуулах ажлын хүрээнд хийгдэх иргэд, олон нийтийн оролцоог хангуулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагатай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | Төслийн хэрэгжилтэд хамтран ажиллах | “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн төлөвлөлтийн танилцуулга, хэлэлцүүлэг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр манай аймагт амжилттай зохион байгуулагдсан. Хэлэлцүүлэгийг Барилгын хөгжлийн төвийн Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Даваанямаар ахлуулсан ажлын хэсэг орон нутгийн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн төлөвлөлтийн шийдэл” сэдвээр илтгэл танилцуулж 150 гаруй хүн хамрагдсан.<br>**Үүний үр дүнд** аймгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон бодлогын баримт бичиг боловсруулагдах юм. | 100 | | |
| | 87 | | II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг | Төсвийн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллах | 1.Аймгийн хэмжээнд Сүмбэр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Шивээговь сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Сүмбэр суманд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгын ажлууд удаашралтай байгаа бөгөөд үнийн өсөлтэй холбоотойгоор удааширч байгаа талаар тайлбар өгөөд байна. Үүнтэй холбоотойгоор БХБС-ын 2022 оны 75 дугаар тушаалаар барилгын материалын үнийн өсөлтийг тооцох материалын жагсаалтыг батлсны дагуу магадлал хийхээр аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлт материалуудыг 2022 онд бүрдүүлэн аймгийн Засаг даргын албан бичгээр БХТ-д хүргүүлсний үндсэн дээр Шивээговь сумын 320 хүүхдийн сургуулийн барилга 800 сая, Сүмбэр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 50сая, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | | барилга 151,0 сая төгрөгийн зөрүү олгохоор магадлал хийгдсэн боловч сургууль цээрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгч нар 2023 онд ажлын цалингийн зөрүүг тооцуулахаар ажиллаж байгааг мэдэгдээд байна.<br>2. Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн А/262 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг удаашралтай байгаа болон ашиглалт хэвийн бус байгаа ажлуудад үзлэг шалгалт хийж, гүйцэтгэгч байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, ажлуудыг эрчимжүүлэх, байнгын ашиглалтад ороход хүндрэлтэй байгаа асуудал, шалтгааныг тодорхойлох, шаардлагатай арга хэмжээг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Дээрхи барилга угсралтын хийгдсэн ажлудад байгуллагын зүгээс 100% хянаэлт хэрэгжүүлэн ажи ллаж байна.<br>**Үүний үр дүнд** холбогдох норм дүрэм, стандартын хэрэгжилт хангагдаж, төсвийн хөрөнгө оруулалт үр ашигтай зарцуулагдах юм. | | | |
| 37 | 88 | 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл 2021-04-14 Дугаар 2021_24 | YIII.4. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрыг бусдад шилжүүлэхгүй байх, бүрмөсөн хориглох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр Сүмбэр суманд 2 сургууль, 2 цэцэрлэгийн газрыг шинээр төлөвлөсөн бөгөөд одоогоор бусдын эзэмшил ашиглалтад олгоогүй нөөцөд байгаа болно. | 100 | | |
| 38 | 89 | 2022 оны 2 | X.5.2021 онд иргэдээс | | Иргэдээс 2023 оны хагас жилийн байдлаар Засгийн | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12 | төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, | | газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд бүртгэдсэн өргөдөл гомдол байхгүй байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | | | | | |
| Сайдын тушаал | | | | | | | | |
| 39 | 90 | Дэд ажлын хэсэг байгуулах тухай<br>2020-09-23 Дугаар 2020_110 | Байгалийн хийн хоолойн төслийг хэрэгжүүлэх зорилгоор "Хийн хоолой дамжуулан барихтай холбогдсон хууль эрх зүйн орчныг судлах, холбогдох баримт бичгүүдийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг"-ийг Шадар сайдын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 110 дугаар тушаалаар байгуулсан байна | Суурь судалгаа, мэдээлэл цуглуулах | 2022 онд Орос, Хятад, Монгол улсын хэлэлцээрийн хүрээнд «Союз восток» хий дамжуулах хоолойн ажилд орон нутгаас хамтран ажиллах ажлын хэсгийг байгуулан мэдээлэл солилцон ажиллаж байгаа бөгөөд 2023 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/244 захиармжаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.<br>“Газ пром” НХН-д Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх хэсэгт барилгын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай инженерийн иж бүрэн судалгаа хийх зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2022 оны А/117 тоот захирамжаар олгосон.<br>Мөн аймгийн Засаг дарга “Газпром” НХН-тай нууцлалын гэрээ байгуулсны үндсэн дээр ажлын хэсгийн нарийн бичиг “Газпром” НХН-ээс хийн хоолойн трассын файлыг хүлээн авсан.<br>Хийн хоолойн трассын дагуух “Инженер экологи”-н судалгааны ажлыг гүйцэтгэгч Жэмр ХХК-ний 2022 оны 66 дугаар тоот албан бичгийн дагуу хий дамжуулах шугам хоолойн трассын дагуу 2км радиуст хамрагдаж буй иргэн, хуулийн этгээдийн эзэмшил газар болон худгийн мэдээллийг байгууллагын 2022 оны 01/263 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br>“Газопровод союз восток” ХХК-иас ирүүлсэн хий дамжуулах хоолойн тэнхлэгээс нь 2 тийш 500 м өргөнтэй зурвас хэсэгт олгогдсон газруудын судалгааг мөн гарган тус тус хүргүүлж хамтран ажиллаж байна. | 100 | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | 90 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | -Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшлийн газрын лавлагааг авах нөхцөл боломжийг ханган мэдээ, мэдээллийг бүрэн оруулж ажиллах | Газартай холбоотой 17 төрлийн лавлагааг E-mongolia цахим системийг ашиглан авах боломжтой болсон.<br>**Үр дүнд:** Газартай холбоотой 17 төрлийн лавлагаа үйлчилгээ E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэмэгдсэнээр иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хаанаас ч өөрийн эзэмшил газрын лавлагаа үйлчилгээг E-mongolia авах боломжтой юм.<br>-Салбарын хэмжээнд барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн баримт бичгийн бүрдэл авах, барилга байгууламжийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх зэрэг иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д нэвтрүүлээд байна.<br>-Мөн барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг urban.gov.mn цахим системээр олгохоор үйл ажиллагааг нэвтрүүлээд байна.<br>Мөн иргэд, олон нийтэд e-mongolia төрийн цахим системээс газартай холбоотой лавлагааг хэрхэн авах талаар сумдад зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан | 100 | | |
| | 91 | | 1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Тоон гарын үсгийг нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Албаны тоон гарын үсгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт уламжлан байгууллагын 12 албан хаагч Үндэсний дата төвөөс 2021 онд бүрэн авсан.<br>-Иргэний тоон гарын үсгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2022-2023 онд 13 албан хаагч авсан.<br>**Үүний үр дүнд:** Тоон гарын үсгийг ашиглан цаг хугацаа хэмнэн үйл ажиллагаандаа ашиглаж байна**.** | 100 | | |
| | 92 | | 1.7.ХУР системд холбогдсон мэдээллийн | ХУР системд холбогдсон мэдээллийг хамтран ажиллах | Хур системд холбогдсон байгууллагатай хамтран ажиллах гэрээг дээд шатанд байгуулан | 100 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | байгууллагатай тогтмол мэдээлэл солилцож ажиллах; | хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>- Татварын ерөнхий газар<br>- Улсын бүртгэлийн ерөнхий газар<br>- ШШГЕГ<br>- Банк<br>- Нотариат<br>- Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагууд хамтран ажиллаж мэдээлэл солилцохоор гэрээ байгуулан ажиллаж байна.<br>**Үр нөлөө:** Ингэснээр газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, зардал чирэгдэлгүйгээр хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлж үйлчилгээг шуурхай үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал: Татварын хэлтэст газрын төлбөрийн ногдуулалтыг хийж, нэхэмжлэхийг цахимаар хүргүүлэх, Улсын бүртгэлийн Э, А дугаарыг цахимаар манай байгууллага шууд авах, банк лавлагааг харах, нотариатын гэрээ цахимаар харах зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж хэвшсэн. | | | |
| | 93 | | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | Цахим үйлчилгээг олон нийтэд болон сурталчлах ажлыг бүх хэлбэрээр зохион байгуулах | Байгууллагын хэмжээнд цахимаар үзүүлж буй үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахаас гадна байгууллагын фэйсбүүк хуудас, байгууллагын цахим сайтад тухай бүр байршуулан ажиллаж байна. Үүнд:<br>• Цахим хуудас буюу Govisumber.gazar.gov.mn сайтанд 11 үндсэн цэс 90 дэд цэсэнд 253 мэдээлэл байршуулсан байна.<br>• Төрийн үйлчилгээг хөдөөгийн багуудийн иргэдэд хүргэх ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хооронд 4, 5, 6 дугаар багийн өдөрлөгт оролцож, 245 иргэнд газрын харилцааны цахим үйлчилгээний талаарх мэдээллийг өгч, гарын авлага тараан ажилласан.<br>Үүний үр дүнд иргэн, хуулийн этгээд газартай холбоотой мэдээ мэдээллийг хэрхэн авах, цахим | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 94 | | | | үйлчилгээний ач холбогдлын талаарх ойлголт сайжирч, цахим үйлчилгээнд сайшаалтай хандаж байгаа нь үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэгдлээс харагдаж байна. | | | |
| | 94 | | 1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | Албан бичгийг цахим системд холбох | ERP mongolia цахим системийг 2022 оноос хойш ашиглаж эхэлсэн. 2023 оны байдлаар ERP цахим системээр ирсэн бичиг 135, явсан бичиг 111 байна.<br>Манай байгууллага нь БХБЯ-аас салбарын хэмжээнд нэгдсэн системээр албан хэрэг хөтлөлтийг 2017 оноос эхлэн ABLE программ ашиглаж хэвшсэн. Үүний дунд ABLE программ болон газрын цахим системүүдээр дамжуулан цахим архивыг үүсгэсэн. | 100 | | |

**БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

| № | Зорилт | Арга хэмжээний тоо | Үүнээс: | | | | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэрэгжих шатандаа | | | Үнэлэх боломжгүй | |
| | | | 100% | 70% | 30% | | |
| 1 | 94 | 94 | 91 | 3 | - | - | 99.04% |

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА Б.ОТГОНЧИМЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН Д.МИШЭЭЛ